



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 111

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө дуудлагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4дэх хэсгийн 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын даргын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,222,640.00 нийт (хоёр сая хоёр зуун хорин хоёр мянга зургаан зуун дөч) төгрөгийн анхны өртөгтэй, 1,274,931.04 (нэг сая хоёр зуун далан дөрвөн мянга есөн зуун гучин нэгэн төгрөг дөрвөн) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий Билгэх үнээний байрыг суурин газрын хамт актлан нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах доод үнийн хязгаарыг 475,000.00 (дөрвөн зуун далан таван мянга) төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Оюунчимэгт даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР